



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Хүүхдийн эмнэлэг” шинээр
байгуулахад шаардлагатай бэлтгэл
хангах, зохицуулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2012-1016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 62 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотод “Хүүхдийн эмнэлэг” шинээр байгуулахтай холбогдуулан байрны асуудлыг шийдвэрлэх, шилжүүлэн авах барилгын засвар үйлчилгээ, ажиллах хүний нөөц, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тооцоо судалгаа хийх, үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Хүүхдийн эмнэлэг” байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг 2015 оны 01 дүгээр сарын 10-ны дотор бэлэн болгож танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Эрүүл мэнд, спортын Дэд сайд Ж.Амарсанаад даалгасугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080002

Эрүүл мэнд, спортын сайдын
2014 оны 12 сарын 10 өдрийн
10 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

**“ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ” ШИНЭЭР БАЙГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ
БЭЛТГЭЛ ХАНГАХ, ЗОХИЦУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: Ж.Амарсанаа, Эрүүл мэнд, спортын Дэд сайд
- Нарийн бичгийн дарга: Я.Амаржаргал, Эрүүл мэнд, спортын яамны
/ЭМСЯ/ Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
- Гишүүд:
- Д.Төмөрбаатар, ЭМСЯ-ны Санхүү, эдийн засгийн
хэлтсийн дарга
- Н.Бат-Эрдэнэ, ЭМСЯ-ны Хуулийн хэлтсийн дарга
- Б.Баярт, ЭМСЯ-ны Хүний нөөцийн удирдлага,
хөгжлийн хэлтсийн дарга
- Н.Гэрэлт-Од, ЭМСЯ-ны Оношилогоо, эмчилгээний
технологийн хэлтсийн дарга
- Г.Соёлгэрэл, ЭМСЯ-ны Эмнэлгийн тусламжийн
хэлтсийн Хүүхэд, өсвөр үеийн тусламжийн бодлогын
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Ч.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
захирал
- Ш.Энхтөр, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний
төвийн захирал
- Ш.Энхбат, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга
- Д.Болортуяа, Төрийн өмчийн хорооны Төрийн
өмчийн бүртгэл, ашиглалт, хэрэгжилт, хяналтын
газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
- Б.Түвшинбаяр, Төрийн өмчийн хорооны Төрийн
өмчийн бүртгэл, ашиглалт, хэрэгжилт, хяналтын
газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Эрүүл мэнд, спортын сайдын
2014 оны 12 сарын 10 өдрийн
01 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

**“ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ” ШИНЭЭР БАЙГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ БЭЛТГЭЛ
ХАНГАХ, ЗОХИЦУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

Зорилго:

“Хүүхдийн эмнэлэг” шинээр байгуулах асуудлыг судлан, бэлтгэл ажлыг хангаж, үйл ажиллагааг эхлүүлэх

Хугацаа:

2014 оны 12 дугаар сарын 15-наас 2015 оны 01 дүгээр сарын 15

Үйл ажиллагаа:

1. Ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөө гаргах
2. Барилгыг шилжүүлэн авах, засвар үйлчилгээ хийлгэх
3. Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн тооцоо, судалгааг үндэслэн шууд худалдан авалт хийх ажлыг зохицуулах
4. Тус эмнэлэгт ажиллах эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудыг бэлтгэх, бүрдүүлж сургах
5. Ажлын хэсгийн санал, үйл ажиллагааны явцыг тухай бүр Эрүүл мэнд, спортын сайдад танилцуулж, санал солилцож байх

Үр дүн:

1. Нийслэл хотод Хүүхдийн эмнэлэг шинээр байгуулахад шаардлагатай тооцоо, судалгаа бэлэн болж, бэлтгэл ажил хангагдана.
2. Эмнэлгийн үйл ажиллагаа эхлэж, нийслэл хотод тулгамдаад байгаа хүүхдийн эмнэлгийн тусламжийн ачаалал зохицуулагдана.